



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

“Багахангай-2024” иргэдийн спортын их наадам
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 3.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Багахангай-2024 иргэдийн спортын их наадам” арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд дүүргийн иргэдийн дунд зохион байгуулсугай.

2.Иргэдийн спортын их наадам зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Иргэдийн спортын их наадам зохион байгуулахад шаардагдах 2,500,000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.“Багахангай-2024 иргэдийн спортын их наадам”-д иргэдийг идэвхтэй хамруулан, оролцоог хангаж ажиллахыг Хороодын Засаг дарга нарт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тайлан, мэдээг нэгтгэж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргэж ажиллахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 24 ны өдрийн 1110 дугаар
захирамжийн хавсралт



“БАГАХАНГАЙ-2024 ИРГЭДИЙН СПОРТЫН ИХ НААДАМ” ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/Д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал
Софт волейбол					
1	1-р байр	ш	1	160,000	160,000
2	2-р байр	ш	1	140,000	140,000
3	3-р байр	ш	1	120,000	120,000
4	Өргөмжлөл	ш	3	10,000	30,000
Нийт					450,000
Ширээний шагайн наадгай					
5	1-р байр	ш	1	180,000	180,000
6	2-р байр	ш	1	160,000	160,000
7	3-р байр	ш	1	140,000	140,000
8	Өргөмжлөл	ш	3	10,000	30,000
Нийт					510,000
Дартс					
10	1-р байр	ш	1	100,000	100,000
11	2-р байр	ш	1	80,000	80,000
12	3-р байр	ш	1	60,000	60,000
13	Өргөмжлөл	ш	3	10,000	30,000
Нийт					270,000
Сагсан бөмбөг					
14	1-р байр	ш	2	200,000	400,000
15	2-р байр	ш	2	180,000	360,000
16	3-р байр	ш	2	160,000	320,000
17	Өргөмжлөл	ш	6	10,000	60,000
18	Шүүгч	ш	1	130,000	130,000
					1,270,000
Нийт дүн					2,500,000